



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Ханбогд хот тохижилт” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ӨМА-2024/29/НА-СТА-ОНА**

Цахим хуудас:

www.Umnugovi@audit.mn

Өмнөговь аймаг

Даланзадгад сум

2024 он

Өмнөговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Одончимэг

Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

Аудитор: Э.Жаргал

Утас: 70533552 Цахим хаяг: jargale@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.03.15 № 258
танай _____-ны № _____-г

ХАНБОГД СУМЫН ХАНБОГД
ТОХИЖИЛТ ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Д.ЭРХЭМБААТАР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ханбогд сумын Ханбогд тохижилт ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Ханбогд сумын Ханбогд тохижилт ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөнд тусгаагүй 2,395,900 төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, албан хаагчийн цолны мялаалгад 1,505,000 төгрөгийн хөрөнгө зарцуулсан, албан хаагчдад хууль тогтоомжид заагаагүй 9,240,000 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, үндсэн хөрөнгийн тооллого хийж тооцоо бодоогүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.2, 12.2.1, 20 дугаар зүйлийн 20.2, 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21 дахь хэсэг, 70 дугаар зүйлийн 2.2.1 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, иж бүрэн байх, оршин байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Сумын Засаг даргын захирамжийн дагуу шороон замын үйлчилгээг хариуцдаг болсноор тайлант онд 35,890,193.72 төгрөгийн ашигтай ажиллан өмнөх оны татварын өр 114,286,212.86 төгрөгийг барагдуулсан байна.

016020475

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 593,632,000 төгрөгийн 3 тээврийн хэрэгслийг бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд шинээр нийтийн тээврийн үйлчилгээг явуулж эхэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	46,061,227.83	177,962,163.72
1.1.2	Дансны авлага	331,554,396.15	323,161,388.00
1.1.6	Бараа материал	26,575,157.45	80,634,082.64
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	23,276,991.87	(0.00)
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	427,467,773.30	581,757,634.36
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,038,467,568.58	1,592,127,581.23
1.2.2	Биет бус хөрөнгө	406,666.59	55,000.00
1.2.9		-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,038,874,235.17	1,592,182,581.23
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,466,342,008.47	2,173,940,215.59
2.1.1.1	Дансны өглөг	12,327,889.33	7,400,000.01
2.1.1.2	Цалингийн өглөг	115,423.00	-
2.1.1.3	Татварын өр	114,483,212.72	27,836,069.46
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	290,644,285.00	290,644,285.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	417,570,810.05	325,880,354.47
2.2	Өр төлбөрийн нийт дүн	417,570,810.05	325,880,354.47
2.3.1	Өмч: - төрийн	741,915,530.50	1,588,427,530.50
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	8,989,041.82	8,989,041.82
2.3.9	Хуримтлагдсан ашиг	297,866,626.10	250,643,288.80
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,048,771,198.42	1,848,059,861.12
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	1,466,342,008.47	2,173,940,215.59

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	585,287,073.49	798,681,549.16
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	626,009,359.43
3	Нийт ашиг (алдагдал)	585,287,073.49	172,672,189.74
4	Түрээсийн орлого	-	128,239,027.27
5	Ерөнхий ба удирдлагын зардал	35,389,743.42	264,889,606.76
6	Санхүүгийн зардал	119,000.00	150,793.38
7	Бусад зардал	557,318,188.69	-
8	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(7,539,858.62)	-
9	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(21,921,736.03)	35,870,816.87
10	Орлогын татварын зардал	-	3,587,081.69
11	Татварын дараах ашиг (алдагдал)	(29,461,594.65)	32,283,735.18
12	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	-	-
13	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(29,461,594.65)	32,283,735.18
14	Орлогын нийт дүн	(29,461,594.65)	32,283,735.18
	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2022 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	276,871,934.05	8,989,041.83	716,592,598.14	1,002,453,574.02
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(142,097,023.98)	(142,097,023.98)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	70,000,000.00	-	-	70,000,000.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-
2023 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	346,871,934.05	8,989,041.83	574,495,574.16	930,356,550.04
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	8,989,041.82	250,643,288.80	259,632,330.62
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	1,588,427,530.50	-	-	1,588,427,530.50
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-
2023 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	1,588,427,530.50	8,989,041.82	250,643,288.80	1,848,059,861.12

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	576,351,471.85	1,026,970,718.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	576,351,471.85	926,284,340.00
	Бусад мөнгөн орлого	-	100,686,378.00
1.2	Мөнгөн зарлага (-)	4,162,490,866.77	884,195,798.19
	Ажиллагчдад төлсөн	178,438,836.00	301,034,835.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	48,609,429.45	64,395,917.51
	Бараа материал худалдан авахад төлсөн	60,881,271.00	66,273,550.00
	Ашиглалтын зардалд төлсөн	76,853,442.64	65,762,929.41
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	134,310,700.00	187,081,287.40
	Хүүний төлбөрт төлсөн	117,000.00	150,793.38
	Татварын байгууллагад төлсөн	123,584,971.64	183,574,286.49
	Даатгалын төлбөрт төлсөн	569,000.00	713,699.00
	Бусад мөнгөн зарлага	15,647,209.90	15,208,500.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(62,660,387.78)	142,774,919.81
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	521,916.08
	Хүлээн авсан хүүний орлого	-	521,916.08
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	11,395,900.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	617,900.00	11,395,900.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(617,900.00)	(10,873,983.92)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(63,278,287.78)	131,900,935.89
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	109,339,515.61	46,061,227.83
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	46,061,227.83	177,962,163.72

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 он			
			Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Борлуулалтын орлого (цэвэр)	585,287,073.49	1,260,690,909.09	926,920,576.43	333,770,332.66	74%
2	Борлуулалтын өртөг	-	-	626,007,192.91	(626,007,192.91)	0%
3	Нийт ашиг (алдагдал)	585,287,073.49	1,260,690,909.09	300,913,383.52	959,777,525.57	23%
4	Үйл ажиллагааны зардал	592,826,932.11	1,113,084,777.27	265,040,400.14	848,044,377.13	24%
5	Үндсэн үйл ажиллагааны ашиг алдагдал	(7,539,858.62)	147,606,131.82	35,872,983.38	111,733,148.44	24%
6	Туслах үйл ажиллагааны орлого	-	-	-	-	-
7	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	-	-	-	-	-
8	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдал	-	-	-	-	-
9	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(7,539,858.62)	147,606,131.82	35,872,983.38	111,733,148.44	24%
10	Орлогын татварын зардал	-	14,760,613.18	3,587,298.34	11,173,314.84	24%
11	Тайланд үеийн цэвэр ашиг (алдагдал)	(7,539,858.62)	132,845,518.64	32,285,685.04	100,559,833.60	24%

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 638,753,0 мянган төгрөгийн НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа илэрснээс аудитын явцад залруулсан байна.

Залруулсан алдаа:

1. Тайлант хугацаанд 19,580.0 мянган төгрөгийн зураг төсвийг бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүргэсэн,
2. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой 617,743,1 мянган төгрөгийн зардлыг бусад зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан,
3. Тайлант хугацаанд 1,429.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч бараа материалын дансанд бүртгэсэн,

Аудитаар нийт 13,140.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 13,140.9 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага, 3 зөрчилд зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

3.2 Албан шаардлага

Илрүүлэлт-1: Тайлант хугацаанд эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөнд тусгагдаагүй 2,395.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан,

Энэ нь Ханбогд сумын ИТХ-ын 2015 оны 21 дүгээр тогтоолоор баталсан байгууллагын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.7 "Дарга нь дор дурьдсан эрх, үүрэгтэй байна", 6.7.1 "Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, газрын дүрэм, зориулалтын санал, бизнес төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах"-д заасантай нийцэхгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт-2: Албан хаагч Б.Пүрэв-очрын цолны мялаалгад зориулан 1,505.0 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан,

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21 "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно", байгууллагын эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөнд тус тус заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт-3: Тайлант онд 257,681.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, оны эхний авлага барагдуулах ажил зохион байгуулаагүй,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт-4: Тайланд тусгасан 652,968.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодоогүй,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", 2.1 "үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор" гэж заасантай тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт-5: Байгууллагын даргын 2023 оны А/09 тоот тушаалаар албан хаагчдад 9,240.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагналыг, урамшуулал, дэмжлэг олгох"-д заасантай нийцэхгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Бараа материалын тооллого хийж, тооцоо бодоогүй байна.

Энэ нь НББОУС -2 Бараа материал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2.2 "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын тооллого, тооцоог хуулийн хугацаанд чанартай хийж хэвших

2. НББ-ийн бодлогын баримт бичиг” шинэчлэн боловсруулахтай холбоотой асуудал

Илрүүлэлт 2: Санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын дарга тушаалаар баталгаажуулаагүй, шинээр батлагдсан хууль, тогтоомжуудтай нийцэхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2

"аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана"-д заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэгдсэн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавруудыг тусган боловсруулж мөрдөж ажиллах

3.Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт3: Бараа, үйлчилгээний худалдан авалтын төлбөрийн Е баримтын зардлыг барааны нэр төрөл, тоо ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлж, анхан шатны баримтад хавсарсан байна

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа, үйлчилгээ худалдан авалт хийх тухай бүрд борлуулагчийн хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг кассын машинаас хэвлүүлэн авч анхан шатны баримтад хавсаргаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацаанд 19,580.0 мянган төгрөгийн зураг төсвийг бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүргэсэн	1	19,580.00			1	19,580.00	1	19,580.00	-	-	-	-
Үндсэн үйл ажиллагаатай холбоотой 617,743.1 мянган төгрөгийн зардлыг бусад зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан	1	617,743.10			1	617,743.10	1	617,743.10	-	-	-	-
Тайлант хугацаанд 1,429.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч бараа материалын дансанд бүртгэсэн	1	1,429.90			1	1,429.90	1	1,429.90	-	-	-	-
Дүн	3	638,753.00	-	-	3	638,753.00	3	638,753.00	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант хугацаанд эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөнд тусгагдаагүй тоног төхөөрөмж худалдан авсан	1	2,395.90			1	2,395.90			-	-	-	-
Албан хаагч Б.Пүрэв-очрын цолны мялаалгад зориулан хөрөнгө зарцуулсан	1	1,505.00			1	1,505.00			-	-	-	-
Тайлант онд авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, оны эхний авлага барагдуулах ажил зохион байгуулаагүй	1	-			1	-			-	-	-	-
Тайланд тусгасан үндсэн хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодоогүй	1	-			1	-			-	-	-	-
Байгууллагын даргын 2023 оны А/09 тоот тушаалаар албан хаагчдад мөнгөн урамшуулал олгосон	1	9,240.00			1	9,240.00			-	-	-	-

/мянган төгрөгөөр/

Бараа материалын тооллого хийж, тооцоо бодоогүй байна	1	-					1	-	-	-	-	-
Санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын дарга тушаалаар баталгаажуулаагүй, шинээр батлагдсан хууль, тогтоомжуудтай нийцээгүй байна.	1	-					1	-	-	-	-	-
Бараа, үйлчилгээний худалдан авалтын төлбөрийн Е баримтын зардлыг барааны нэр төрөл, тоо ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлж, анхан шатны баримтад хавсарсан байна	1	-					1	-	-	-	-	-
Дүн	8	13,140.9	-	-	5	13,140.9	3	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 3 гүйлгээ буюу 36,905.1 төгрөгийг мэдээлээгүй	1	36,905.10			1	36,905.10		
нэгдсэн системд дараа жилийн зорилтот түвшин, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, мэдээллийг тус тус байршуулаагүй	1	-			1	-		
Дүн	2	36,905.10	-	-	1	36,905.10	-	-
Бусад хууль, тогтоомжтой холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд тоног төхөөрөмж худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй	1	-					1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-
Нийт дүн	3	36,905.10	-	-	3	36,905.10	1	-

